

2024.01.02

05



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 17/58

Номгон

Тусгай зориулалтын ангийн дуудлага
худалдаанаас орсон орлогыг хуваарилах
тухай

Монгол Улсын Амьтны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29¹.13 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 5-ны өдрийн 02 дугаар Журам шинэчлэн батлах тухай тогтоол, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.1, Засгийн газрын 02 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.4.2-д заасныг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Баянхонгор аймгийн тусгай зориулалтын ангийн дуудлага худалдаанаас орсон 285,670.0 сая төгрөгийн 50% буюу 142,835.0 сая төгрөгийг Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлж, 50%-ийг аймгийн агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг санхүүжүүлэхийг дэмжсүгэй.

2.Агнуур зохион байгуулалтын тайлан, агнуурын менежментийн төлөвлөгөөнд тулгуурлан ан амьтдыг хамгаалах, зохистой ашиглах, бодлого боловсруулж, бодлогын хэрэгжилтийг хангаж, агнуурын нөөцийг зохистой ашиглахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ



0121370